

# АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

## ГЭРЭЭ

20<sup>14</sup> оны 01 дугаар  
сарын 03-ны өдөр

дугаар АӨҮА-2014/03/ 04

Улаанбаатар  
хот

### Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт Малтмалын Газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас XV-007559 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улаанбаатар хотын Үндэсний татварын ерөнхий газарт бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 9019033118 тоот гэрчилгээ, 5198429 регистрийн дугаартай “Өү Жи Си Эйч Эл” ХХК (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 078 тоот тушаалаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Замын амны алтны шороон ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үеийн хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - a. Ордыг ашиглах зураг төсөл боловсруулах;
  - b. Ордын нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулах;
  - c. Уурхай барьж байгуулах;
2. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг 2016 оны 04 дүгээр сарын 20-ны дотор хийх.
3. Ордын технологийн туршилтын хугацаа 1,5 жил байна.
4. Орд ашиглах төслийн хүчин чадалд хүрэх хугацаа 2,4 жил байна.
5. Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Замын амны алтны шороон ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөр дуусгавар болно.

### Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 48-д заасныг үндэслэн АМГ-ын даргын 2009 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан АМГ-ын ГСХ-ийн “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын жилийн тайлан хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тооцох” дотоод зааврын дагуу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хайгуулын ажлын тайланг ГСХ-т хүргүүлж хайгуулын ажлын доод

хэмжээг баталгаажуулж, хуулбарыг гэрээний биелэлтийн тайлангийн хамт гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш (1) жил тутам УУСХ-т ирүүлнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлтэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.

5. Орд ашиглахтай холбогдсон баримт бичгийг Монгол хэл дээр үйлдсэн байна.

6. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албандаа тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.

7. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хайгуул судалгааны ажил хийгээгүй талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх.

8. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

### **Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг**

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.
2. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.
3. Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.
5. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг бичгээр авсан байна.

### **Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл.**

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хулээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг бүрэн хариуцна.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын XV-007559 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
5. Гэрээг 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын Уул уурхайн асуудал хариуцсан нэгжид, 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төв архивт тус тус хадгална.

6. Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### **Ашигт малтмалын газрыг төлөөлж:**

Уул уурхайн хэлтсийн  
дарга... *С.Баттулга*



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:  
“Оу Жи Си Эйч Эл” ХХК-ийн гүйцэтгэх  
захирал LC ..... Жеймс Долан

захирал ЛС ..... Жеймс Долан

ЭХ СҮРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

# АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

## ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Замын амны алтны шороон ордын XV-007559 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Өү Жи Си Эйч Эл” ХХК-тай байгуулсан № АӨҮАГ-2014/03/04 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2014/03/04) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1. Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Замын амны алтны шороон ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-007559 тоот тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөр дуусгавар болно.
2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.
3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.
4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.



Ашигт малтмалын газрыг төлөөлж:  
Уул уурхайн хэлтсийн дарга  
..... С.Баттулга

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

“Өү Жи Си Эйч Эл” ХХК-ийн захирал

..... Lo Lin Shing Saimon



УЛААНБААТАР ХОТ ТТ49103 № 5198429

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://www.iltodgerree.mn)

Дэвиж



**Хайгуулын тусгай зөвшөөрөл:**

Эзэмшигч:	Өү Жи Си Эйч Эл	Олгосон огноо:	2004.05.24
Талбайн нэр:	Тэрэгтийн нуруу	Дуусах огноо:	2016.04.13
Талбайн хэмжээ:	2000.01 Га	Барьцаалсан байдал:	---
Байршил:	Говь-Алтай (Алтай)	Шүүхэд хэлэлцэгдэж буй эсэх:	---
Ашигт малтмал:	---	Планшетийн дугаар:	L-46-131

**Өргөдлүүд:**

Код	Төрөл	Бүртгэсэн огноо	Одоогийн байдал
XV-007559-000-CI	[CI] Цэгцлэгдсэн өгөгдөл	2010.02.09	47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцслэх
XV-007559-001-NE	[NE] Шинэ хайгуулын тусгай зөвшөөрөл	2004.05.10	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-002-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2005.05.19	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-003-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2006.05.02	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-004-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх өзэмшигч: Алтандорнод монгол)	2006.03.06	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-005-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2007.04.23	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-006-EE	[EE] Хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгах	2007.04.26	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-007-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх өзэмшигч: Ажминералс)	2007.05.01	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-008-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх өзэмшигч: Коммонмакс)	2007.07.02	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-009-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2008.05.06	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-010-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх өзэмшигч: Эм Би Жи Эйч Эл)	2008.07.10	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-011-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2009.04.23	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-012-EE	[EE] Хайгуулын тусгай зөвшөөрлийг сунгах	2010.05.13	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-013-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2010.06.09	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-014-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх өзэмшигч: Эм Өү Өү Ай Си Өү)	2011.05.02	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-015-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2011.05.26	19-Батлагдсан өргөдлийг эцэсл

37	2016.04.04	07/215	Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	2626	Хөх шутамж ХХК, Заамарын их алт ХХК-ийн гэрээний тухай	2016.04.06		Хадаад 09.05
38	2016.4.5	7	Архангтай аймгийн Цэнхэр сумын ИТХ Алтай констракшии ХХК	2721	Монгол газар, Алагандорнод ХХК-иудын үйл ажиллагааны тухай	2016.04.08		Хадаад 09.05
39	2016.4.7	02/371		2739	Хүсэлт гарах тухай MY-014760	2016.04.08	MY-014760 АГЗ-ийг геологичид нь олгов.	Хадаад 09.05
40	2016.4.7	16/4/1	Хус мөд ХХК	2740	Хүсэлт гарах тухай XY-12576	2016.04.07	KХ-т шилжүүлэв.	KХ
41	2016.3.21	16/03/21	Гурват ХХК	2812	MY-12049 гэрээ байгуулж ажиллах тухай	2016.04.18	Тунгаад танилцуулав. Ажлын хэсэг газар дээр нь ажилласан.	Хадаад 09.05
42	2016.4.11	041/03	Ньюголден кроуна ХХК	2824	MY-011648 гэрээ байгуулж ажиллах тухай	2016.04.18	Тунгаад танилцуулав. Ажлын хэсэг газар дээр нь ажилласан.	Хадаад 09.05
43	2016.4.12	16-Apr	НАБД ХХК	2840	MY-015645 цушлах асуудлыг хойшлуулах тухай	2016.04.19	Хүсэлгээй танишдаж нэдсэн бүртгэлд бүртгэв.	Хадаад 09.05
44	2016.4.12	01/165	Жи Эс Би майнинг	2841	MY-005411 Тусгай зөвшөөрлийг буцсан авах тухай	2016.04.18		Хадаад 09.05
45	2016.04.13	1/07	Завтайж ХХК	2868	MY-017021 АГЗ-ийн асуудлыг шийдвэрлэрийг хойшлуулах тухай	2016.04.18	БОНХАЖ-НЫ 2016.04.05-ны 04/1828 тоог дүгнэлт, БОНХАЖ-ЫН САЙДЫН	Хадаад 09.05
46	2016-04-15	02-Apr	Наран голуд ХХК	2973	MY-015424 гэрээ байгуулж ажиллах тухай	2016-04-20	2016.03.04-НИЙ А/67 тоог тушаал хөвсрөлтийн хамт, БОНХАЖ-ЫН 2016.04.14-НИЙ 04/2066 тоог лавлагануудын хуулбар, 1ш CD	Хадаад 09.05
47	2016-04-18	016/025	Жи энд Юу голд ХХК	3022	MY-012806 ТЗ-ийн хасалт хийгэсэн талбайг буцаан авах тухай	2016-04-20		
48	2016.04.20	01/09	Шинэ шуудан	3128	Хайгуульн төсөл хэрэгжихүй байгаа үндэстэл XY-015433	2016.04.27	ГА нөхөн олговрын Материалыг СЯ-д хургуулэхээр бэлтгэж бна.	Хадаад 09.05

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)





Ашигт малтмал газрын тосны газар  
Кадастрын хэлтэс

Тусгай зөвшөөрлийн  
дэлгэрэнгүй мэдээлэл  
ТЗ-ийн дугаар: ХВ-007559

141

XV-007559-016-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2012.04.18	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-017-NM	[NM] Шинэ ашиглалтын тусгай зөвшөөрөл	2014.02.13	29-Татгалзсан өргөдлийг эцэсл
XV-007559-018-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2014.01.23	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-019-SPR	[SPR] Хэсэгчлэн буцааснаас үүдэж багасах	2014.02.20	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-020-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2014.02.28	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-021-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2014.05.01	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-022-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2014.12.03	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-023-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2015.05.11	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-007559-024-SF	[SF] Бүхэлд нь буцааж өгөх	2016.04.12	19-Батлагдсан өргөдлийг эцэсл

**Эзэмшигчийн бүртгэл:**

Нэр: Өү Жи Си Эйч Эл  
 Аж ахуйн нэгжийн төрөл: гадаадын 100 хувь хөрөнгө  
 оруулалттай Утас: 70110567, 70110569  
 Бүртгэлийн дугаар: 5198429 Гар утас: 99116861  
 Улсын бүртгэлийн Факс: 77110570  
 дугаар #:  
 Улс: Сингапур Е-мэйл: www.mongolia-energy.com  
 Захирлын овог, нэр: Ло Лин Шинг Саймон Ло Лин Шинг  
 Саймон

**Эзэмшигчийн хаяг:**

Гудамж: Сөүлийн гудамж Түшиг төвийн 3 Шуудангийн хайрцаг: ---  
 давхарт  
 Хот: Улаанбаатар ZIP код: 14250  
 Аймаг/ Хот: Улаанбаатар  
 Сум/ Дүүрэг: Сүхбаатар  
 Баг/ Хороо: 4-р хороо

**ТЗ-ийн солбицол:**

Олон өнцөгт	#	Уртраг			Өргөрөг		
		град	мин	сек	град	мин	сек
Ex1	1	95	26	24.48	44	36	45.66
Ex1	2	95	22	29.99	44	36	45.66
Ex1	3	95	22	29.98	44	38	51

Хэвлэсэн огноо: 2016.10.04 15:02

ЭХ СҮРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

28	2016.3.18	6/506	ҮҮЯ	2160/748	Хуулийн хэрэгжилтийн тайлан ирүүлэх тухай	2016.03.21	2016.03.17-ны өдөр Отгонхагвад мэйлээр хүргүүлсэн.	Хадаад 09.05
29	2016.3.21	03/07	Мик майнинг ХХК	2212/771	Энгийн хамгаалалтын бусэд олборлолтын Ү/а явуулах гэрээ хийсээ эсэх талаар тодорхойлолт хүсэх тухай	2016.03.29	2016.04.01 5/2056	
30	2016.3.23	03/142	Монгол газар ХХК	2288	5529, 2426, 2427 АТЗ-ҮҮД нь Ург нэртэй хуулийн Үйлчлэлээс бүрэн чөлөөлөгдсөн тул Ү/а ургалжкуулэн явуулах тухай	2016.03.28	Тулгант хийж мэдээллийн санд бүртгэв.	
31	2016.3.23	03/07	Эм Жи Эйч ХХК	2290	9258А, 7207А АТЗ-ҮҮД нь хуулийн Үйлчлэлээс гарсан учир Ү/а Ургажжүүлэн явуулах тухай	2016.03.28	Тулгант хийж мэдээллийн санд бүртгэв.	
32			Итгэл түүнгүй ХХК	2292/806	14934Х Тодорхойлолт гаргуулах тухай	2016.03.24	2016.03.24 5/1857	
33	2016.3.23	4	Сагсаймнекерл ХХК	2294	XY-015628 АӨҮАГ сунгуулах тухай	2016.03.28	Гэрээ 3 жилийн өмнө байгуулагдсан. Шинээр гэрэ байгуулах болон, сунгах асуудал яригдахгүй байна.	
34	2016.3.30	16/02	Брэйвхарт Ресурсиз ХХК	2473	XY-007340, XY-008018 АӨҮАГ дүгнэх тухай	2016.03.31	Гэрээний дагуу хийсэн ажлаа, ноглох баримтын хамт авчрах тухай мэдэгдэв.	
35	2016.3.30	16/18	Бүүрэгтэн ХХК	2486	MY-003512 АТЗ-ийн эрх сэргээгдсэн тул ТЗ-ийн, хавсралтын хамт буцаан авах тухай	2016.03.31	ТЗ сэргээгдсэн боловч ОС-тай 100% давхцалтай учир БОНХАЖЯ-д хандаж ойн асуудлыг шийдвэрээний дараа АТЗ олгох боломжтой тухай 991117402 лхагдант мэдэгдэв.	
36	2016.3.29	03/291	Монголын алт МАК ХХК	2508	MY-007357 АТЗ нь ург нэртэй хуулийн Үйлчлэлээс гарсан учир тусгай зөвшөөрлийг хавсралтын хамт буцаан авах тухай	2016.03.31	2015.04.04-ний өдөр Гэрэлхүүд компанийн итгэмжлэлийг үндэслэн олгов.	

ЭХ СУРВАЛЖ: [www.iltodgerree.mn](http://www.iltodgerree.mn)





Ашигт малтмал газрын тосны газар  
Кадастрын хэлтэс

Тусгай зөвшөөрлийн  
дэлгэрэнгүй мэдээлэл  
ТЗ-ийн дугаар: XB-007559

Ex1

4

95

26

24.48

44

38

51

Хэвлэсэн огноо: 2016.10.04 15:02

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

15	2016.2.18	04/2016	Арвин цайдам	1444	XV-007155 АӨҮАГ дүгнүүлэх тухай	2016.02.20	АӨҮАГ дүгнэсэн акт №2016/5	Хадаад
16	2016.2.18		Би Ар Икс	1440	ХТЗ-ийн хоригилсон талбайтай давхцалтай байгааг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай	2016.02.20	Баттулга даргын цохолгоор НХ-т шилжүүлэв.	НХ
17	2016.2.22	16/03	Налгар хөндий	1542	Ашиглалтын өмнөх гэрээ дүгнүүлэх тухай 7438Х	2016.02.25	Материал авчирч өгөх тухай мэдэгдэв. 9901664	
18	2016.2.26		02/01 Наран гоулд	1645	ЭХБ-д олборлолтын У/а явуулсан тухай дүгнэлт гаргуулах	2016.03.01	Мөнхсайханд танишиулав.	Хадаад 09.05
19	2016.2.16	03	Марикоманхан ХХК	1779	5/833 тоотын хариу	2016.03.04	Энгийн хамгаалалтын бусэд олборлолтын У/а явуулахыг зөвшөөрөх тухай	
20	2016.2.29	01/04	Даланбулаг трэйд ХХК	1800	Гэрээ байгуулах тухай	2016.03.07	Уулын ажлын тайлан, уулын ажлын дэвсгэр зургийн хамт хамт мэргэжилтэн Мөнхсайханд авчирч өгөх тухай 91117038 дугаарт холбогдох өгөв.	Мөнхсайханд шилжүүлэсн.
21	2016.3.9	03/01	Толгойтын гол ХХК	1941	Төлбөр шилжүүлэн тооцох тухай	2016.03.14	Кадастрын хэлтэст шилжүүлэв.	КХ
22	2016.3.9	16/27	Буургэнт ХХК	1943	Хүсэлт гаргах тухай 6854А	2016.03.14	Хуулбарлаж өгөв.	
23	2016.3.10	16/27	АГМ майнинг ХХК	1994	Гэрээ дүгнэх тухай 7305Х	2016.03.14	АӨҮАГ дүгнэсэн акт №2016/4	Очирихяг 91927013
24	2016.3.14	16/05	Баярсгуулд ХХК	2017	Тусгай зөвшөөрөл түр авах тухай МҮ-018764	2016.03.15	АТЗ нь манайд хүлээлгэж өгөгүй тухай мэдэгдэв.	
25	2016.3.15	1/03	Даланбулаг трэйд ХХК	2054	Үйл ажиллагаа сэргээлгэх тухай	2016.03.17	Мөнхсайханд шилжүүлэв.	
26	2016.3.15	16/03	Нью хапни ХХК	2124/734	178А тодорхойлolt хүсэх тухай	2016.03.20	2016.03.23 5/1817	
	2016.3.17	21	НАБД ХХК	2151	МҮ-015645 талбайд Үйл ажиллагаа Ургэлжлүүлэн явуулдах тухай	2016.03.18	91993832 дугаарт запгаж ирж уулзах талаар мэддэгдэв.	

ЭХ СУРВАЛЖ: [www.iltodgerree.mn](http://www.iltodgerree.mn)

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ  
ДУУСГАВАР БОЛСОН ТУХАЙ АКТ №2016/21

2016.10.04

Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Замын амны алтны шороон ордын XV-007559 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг “Өү Жи Си Эйч Эл” ХХК бүхэлд нь буцаан өгсөн тул Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 279 тоот тушаалаар тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг дуусгавар болгосон байна.

Иймд Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмын 6.1.3-д заасны дагуу Ашигт малтмалын газар /одоогийн АМГТГ/ болон “Өү Жи Си Эйч Эл” ХХК нарын харилцан тохиролцож байгуулсан 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн №АӨҮА-2014/03/04 тоот ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг дуусгавар болгов.

Жич: АМГ-ын Кадастрын хэлтсийн CMCS программаас XV-007559 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг хуулбарлан хавсаргав.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ХАНГАЙ

Боловсруулсан: УУҮТХ-ийн мэргэжилтэн *С. Оюунтуяа* Г.Оюунтуяа

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)